

Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн бүртгэлд
2023 оны 06 сарын 16-ны
өдрийн 6253 дугаарт бүртгэв.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА,
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН
САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2023 оны 06 сар 12 өдөр

Дугаар 318 / А/231


Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.10, 16 дугаар зүйлийн 16.1.5, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 3.2, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн 188 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны болон ханшийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, ашиглах, мэдээллийг нийтэд хүргэх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны даргад тус тус даалгасугай.



Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Уул
уурхай, хүнд үйлдвэрийн сайдын
2023 оны 6 дугаар сарын 12 -ны өдрийн
318/А/231 дугаар хамтарсан тушаалын хавсралт

УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН АРИЛЖААНЫ БОЛОН ХАНШИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН БҮРДҮҮЛЭХ, АШИГЛАХ, МЭДЭЭЛЛИЙГ НИЙТЭД ХҮРГЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмаар уул уурхайн бүтээгдэхүүний бирж (цаашид “бирж” гэх)-ийн арилжааны болон ханшийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, ашиглах, нийтэд мэдээлэх мэдээллийн агуулга, жагсаалтыг тодорхойлох, мэдээлэх хугацаа, түүнийг хянах, ашиглах, хадгалахтай холбоотой харилцааг зохицуулна.

Хоёр. Биржийн арилжааны болон ханшийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх

2.1. Бирж нь арилжааны болон ханшийн нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлнэ.

2.2. Биржийн арилжааны болон ханшийн нэгдсэн мэдээллийн санд дараах мэдээлэл багтсан байна:

2.2.1. арилжаанд оролцогчийн өгсөн захиалга, захиалгын огноо;

2.2.2. арилжаалсан бүтээгдэхүүний хэлцэл хийгдсэн он, сар, өдөр, тухайн бүтээгдэхүүний бүртгэлийн дугаар, ялгах тэмдэг;

2.2.3. арилжаалсан бүтээгдэхүүний төрөл, ангилал, үсгэн код;

2.2.4. арилжаалсан бүтээгдэхүүний үнэ, ханш, ханшийн хэлбэлзэл;

2.2.5. арилжаалсан бүтээгдэхүүний хэмжээ;

2.2.6. арилжаалсан гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл;

2.2.7. шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл.

2.3. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч /брокер/ (цаашид “брокер” гэх) нь дараах мэдээллийг хөтөлж, харилцагчтай холбоотой мэдээллийн санг бүрдүүлнэ:

2.3.1. харилцагчийн нэр, хаяг, ажил мэргэжлийн талаарх мэдээлэл;

2.3.2. харилцагчийн гүйлгээний дэлгэрэнгүй мэдээлэл;

2.3.3. харилцагчийн захиалгын бүртгэлийн мэдээллийг тухайн захиалга өгсөн цаг, огноо, хэлцлийг арилжаанд оруулсан цаг, огнооны хамт;

2.3.4. харилцагч тус бүрийн хөрөнгийн гарал үүслийн талаарх мэдээлэл болох бүх арилжаа, орлого, зарлагын талаарх мэдээллийн хамт.

2.4. Бирж нь дараах мэдээллийг энэ журмын хавсралтаар баталсан маягтын дагуу үнэн зөв бэлтгэж, Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх) болон Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ:

2.4.1. арилжааны мэдээг тухайн сар, улирлаар;

2.4.2. арилжаанд оролцогч худалдагч, худалдан авагч талын гүйлгээний мэдээллийг тухайн сар, улирлаар;

2.4.3. шимтгэлийн мэдээг тухайн сар, улирлаар;

2.4.4. арилжааны нэгдсэн тайланг бүтээгдэхүүн тус бүрээр, тухайн улирал, жилээр.

2.5. Бирж нь сар бүр ирүүлэх мэдээллийг цахим хэлбэрээр Хороонд, улирал болон жилээр ирүүлэх мэдээллийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр Хороо болон Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

2.6. Энэ журамд заасан сар бүр ирүүлэх мэдээллийг дараа сарын 10-ны өдөрт, улирал бүр ирүүлэх мэдээллийг дараа улирлын эхний сарын 10-ны өдөр, жилийн эцсийн мэдээллийг дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор тус тус багтаан хүргүүлнэ.

2.7. Хороо нь ирүүлсэн тайлан, мэдээлэлд хяналт тавих бөгөөд шаардлагатай тохиолдолд тайлан, мэдээлэлтэй холбоотойгоор нэмэлт асуулга, тодруулгыг биржээс гаргуулан авна.

2.8. Хороо шаардсан тохиолдолд бирж нь энэ журмын 2.2, 2.7-д заасан мэдээлэл, асуулга, тодруулгыг, брокер нь энэ журмын 2.3-т заасан мэдээллийг түүнд хүргүүлнэ.

Гурав. Мэдээллийг нийтэд хүргэх

3.1. Бирж нь мэдээллийг нийтэд хүргэхтэй холбоотой харилцааг зохицуулсан дотоод журамтай байх ба дараах мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд тогтмол хүргэнэ.

3.1.1. арилжааны мэдээ;

3.1.2. уул уурхайн бүтээгдэхүүн тус бүрийн ханшийн мэдээлэл;

3.1.3. биржид бүртгэлтэй, итгэмжлэл олгосон агуулах, терминал, тээвэр логистикийн төв, шинжилгээний лабораторийн жагсаалт, дэлгэрэнгүй мэдээлэл;

3.1.4. нийт худалдах, худалдан авах уул уурхайн бүтээгдэхүүний хэмжээний дүн;

3.1.5. фьючерс, опцион гэрээний нээлттэй позицийн хэмжээний дүн;

3.1.6. арилжааны тайланд үндэслэн сар, улирал болон жилийн эцсийн нэгдсэн тойм мэдээлэл;

3.1.7. Арилжаатай холбоотой дүрэм, журам, заавар.

Дөрөв. Мэдээллийн хадгалалт

4.1. Биржийн нэгдсэн мэдээллийн сангийн аюулгүй байдлыг бирж хариуцна.

4.2. Биелэгдээгүй захиалгын мэдээлэл захиалгын сангийн архивд хадгалагдана.

4.3. Баталгаажсан захиалгатай холбоотой аливаа маргаан гарсан тохиолдолд захиалгын сангийн архивд хадгалагдсан мэдээллийг үндэслэн уул уурхайн бүтээгдэхүүний биржийн дэргэдэх маргаан таслах зөвлөл шийдвэр гаргаж болно.

4.4. Бирж болон брокер нь мэдээллийн сангийн мэдээлэл, холбогдох баримт материалыг цахим болон цаасан хэлбэрээр хадгална.

Тав. Мэдээллийн ашиглалт

5.1. Хороо болон Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 2.4-т заасан мэдээллийг тойм мэдээлэл гаргах, судалгаа шинжилгээ хийх, салбарын хөгжлийн бодлогыг боловсруулах зорилгоор ашиглана.

5.2. Хороо энэ журмын 2.4-т заасан мэдээллийг зайны болон газар дээрх хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх зорилгоор ашиглаж болно.

5.3. Энэ журмын 2.4-т заасан мэдээллийг энэ журмын 5.1, 5.2 дахь хэсэгт зааснаас бусад хувийн зорилгоор ашиглахгүй.

5.4. Монголбанк, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, шүүх, прокурор, цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын удирдлагаас бичгээр хүсэлт ирүүлсэн тохиолдолд Хороо болон Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 2.4-т заасан мэдээллийг, бирж нь арилжааны болон ханшийн мэдээллийн сан, брокер нь харилцагчтай холбоотой мэдээллийн нэгдсэн сангаас холбогдох мэдээллийг хүргүүлнэ.

5.5. Хороо энэ журмын 5.4-т зааснаас гадна харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан байгууллагад Хорооны нэгжийн удирдлагын зөвшөөрлөөр холбогдох мэдээллийг хүргүүлж болно.

ooOoo

Хүснэгт 3.Биржийн шимтгэлийн мэдээ (тухайн сар, улирлаар)

Арилжааны шимтгэл	Арилжааны дүн	Арилжаалагдсан багцын хэмжээ	Худалдах захиалгын шимтгэл		Худалдан авсан захиалгын шимтгэл		Тухайнсард биржийн дансанд төвлөрсөн шимтгэлийн орлогын дүн (төгрөг)
			Шимтгэлийн хувь	Шимтгэлийн хэмжээ	Шимтгэлийн хэмжээ	Шимтгэлийн хувь	

Хүснэгт 4.Биржийн арилжааны нэгдсэн тайлан (бүтээгдэхүүн тус бүрээр, тухайн улирал, жилээр)

Д/д	Хамрах хугацаа	
1	Нийт арилжаа хийсэн компанийн тоо /худалдагч тал/	
2	Нийт хийгдсэн хэлцлийн тоо	
3	Цахим арилжаанд оролцсон худалдан авах санал гаргагчдын тоо	
4	Валютын төрөл	
5	Хэлцэл хийгдсэн дундаж үнэ /валют 1/	
	Хэлцэл хийгдсэн дундаж үнэ /валют 2/	
6	Үнийн өсөлтийн дундаж хувь /валют 1/	
	Үнийн өсөлтийн дундаж хувь /валют 2/	
7	Гэрээний нийт үнийн дүн /валют 1/	
	Гэрээний нийт үнийн дүн/ валют 2/	
8	Хэмжээ /тонн/	
9	Арилжсан багцын тоо	